



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/105/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

	Агуулга
Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.БАТЦЭЦЭГ ТАНАА

2020.02.27 № 2/2
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020172

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтэрсэн.

- Өмнөх он буюу 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон 5958,0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоон, зөвлөмж өгсөн байхад 2019 онд өдөр дээрх алдааг давтан гаргаж 9302,7 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"
- Бараа үйлчилгээний зардал, болон бусад зардлаас тушаал шийдвэргүй, анхан шатны баримтгүй, зориулалт бус зардал гаргадаг зэрэгт 36944,7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 18-нээс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Эрүүл мэндийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн нотолгоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлснээр хүн амд ээлтэй тэгш хүртээмжтэй чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад өгөх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудал горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1177431,1 мянган төгрөгөөс тооцон 11774,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 18549,1 мянган төгрөгөөр тооцов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34256,4 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2000.00	5000.00	3000.00
Авлага	30600.00	7551.60	-23048.40
Урьдчилгаа	0.00	122.35	122.35
Бараа материал	41043.31	92793.07	51749.76
Үндсэн хөрөнгө	1221629.57	1224062.25	2432.68
Хуримтлагдсан элэгдэл	1295272.88	1329529.26	34256.38
Нийт хөрөнгө	30802.98	0.00	-30802.98
Өр төлбөр	1264469.90	1329529.26	65059.36
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1295272.88	1329529.26	34256.38
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2000.00	5000.00	3000.00

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 5000,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос 3000,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 23048,4 мянган төгрөгөөр буурсан нь урд оны нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн 30600,0 мянган төгрөг орлого орж зарцуулагдсан ба 2019 оны нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн 7551,6 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна. Хүүхдээ асарсны чөлөө авсан эхийн цалингийн урьдчилгаа 122,3 мянган төгрөг нь урьдчилгаа авлагын дансанд үлдэгдлээр гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 51749,7 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын зардал 48888,5 мянган төгрөг, түлш шатахууны зардал 4754,4 мянган төгрөг, сэлбэг хэрэгслийн зардал 1275,0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Эм боох материалд 48888,5 мянган төгрөг үлдсэн нь вакцин био бэлдмэл, тариур дагалдах хэрэгслийн үлдэгдэл 26824,3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн

данснаас 2019 оны 12 сарын 26-нд Монос трейд ХХК руу В,С вирусны илрүүлэг тест 9648,0 мянган төгрөг, тэмбүүний түргэвчилсэн оношлуурын тест 9700,0 мянган төгрөг, илрүүлэг үзлэгт шаардлагатай нэг удаагийн бээлий, өндөг цоологч үнэ 3000,0 мянган төгрөг шилжүүлж орлого авсантай холбоотой байна. Харин түлш шатахууны хувьд шатахууны 4754,4 мянган төгрөгөөр нөөцөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97912,9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13912,9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, хандиваар 84000,0 мянган Ниссан патрол автомашин авсантай холбоотой байна.

Программ хангамж 275,0 мянган төгрөгөөр өссөн нь нярвын программ авсан, бусад биет бус хөрөнгө нь 2000,0 мянган төгрөгөөр өссөн нь “Энэрлийн наран” сүлд дууг орлого авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 30803,0 мянган төгрөгөөр буурсан нь 30600,0 мянган төгрөг нь 2018 оны нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 30600,0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж 2019 онд буцаан орж зарцуулагдсан, хувь хүмүүст төлөх өглөг 203,0 мянган төгрөг барагдуулсантай холбоотой байна. 2019 оны эцэст өглөггүй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1329529,3 мянган төгрөг болж 65059,4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 96495,6 мянган төгрөг болсноос шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Үндсэн үйл ажиллагааны зардалд 717988,5 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 12941,0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 693217,7 мянган төгрөг, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардалд 18555,8 мянган төгрөг, нийт 1442703,0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1442703,0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1393324,4 мянган төгрөг буюу 96,6 хувьтай байгаа нь 49378,6 мянган төгрөгийг хэмнэж буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Үүнээс Цалин НДШ-ийн зардлыг 29774,3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн 47 орон тоо батлагдсан гүйцэтгэлээр 44 орон тоотой ажилласантай, урсгал засварын зардлыг 6945,8 мянга, цэвэр бохир ус 4914,2 мянган төгрөгөөр мөн бусад зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Тусгай зөвшөөрлийн үнэ 310,0 мянга, сорьц тээвэрлэлтийн санхүүжилт 1080,0 мянга, дархлаажуулалтад нэвтрүүлэх саагийн эсрэг вакцины сургалтын зардал НҮБ санхүүжилт /Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө сургалтын зардал 12652,6 мянга, Орчны эрүүл мэнд, үр нөлөө сургалтын зардал 960,0 мянга, БЗБХ-ийн оношилгоо 7688,4 мянга, Үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтын зардал 2210,0 мянга, Олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ сургалтын зардал 5084,0 мянга, Дэд сайдын ажлын хэсгийн томилолт 1548,0 мянга, Монтиринг хийх ажлын санхүүжилт 21267,5 мянга/ 51410,5 мянга, цахим тендерийн хураамж 693,0 мянга урд оны төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт 30600,0 мянга, вакцин тээвэрлэлтийн хөлс 2569,6 мянга, Говь-Алтай ЭМГазраас оролцооны мөнгө 500,0 мянга, Уул уурхайн цогц үзлэгийн зардал 5947,2 мянга, тэмбүүг устгах зардал 8390,0 мянга, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Зориулалт бус хуванцар савны хэрэглээнээс татгалзая” уралдааны зардалд 3270,0 мянга, ахмадын сан 5000,0 мянга нийт 145025,8 мянган төгрөгийн орлого төвлөрч 132474,2 мянган төгрөгийн зардал гарч 7551,6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, тайланд авлагаар, ахмадын сан 5000,0 мянган төгрөг үлдэгдлээр санхүүгийн тайланд тусгагдсан байна

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 35 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 26 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитаар нийт 50391,4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10541,5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 2150,0 мянган төгрөгийн албан шаардлага, 37699,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	33555,9	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	10541,5	
3	Албан шаардлага өгсөн	1	2150,0	
	Дүн	7	46247,4	

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар дараах 46247,4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10541,5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

Үүнд:

1. Тус газар нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн улирал бүр ажилтнуудын ажлыг дүгнэж урамшуулал олгосон атлаа 12 дугаар сард Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 12 сарын 19-ны өдрийн А/144 дугаар тушаалаар жилийн эцсийн ажлын гүйцэтгэлээр 9302.7 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах журмыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Бараа үйлчилгээний зардлаас тушаал шийдвэр гаргалгүй иргэн Б.Алтанцэцэгээс 187.0 мянга, Мядагмаагаас 153.0 мянга, Цогзолмаагаас 432.3 мянга, Ч.Энэбишээс 466.5 мянга, нийт 1238.8 мянган төгрөгөөр цагаан идээ худалдан авч шаардах хуудсаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг

хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах журмыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Зүүн шанд ХХК руу 2019.12.26-нд урсгал засварын зардалд 2150.0 мянган төгрөгийг барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулаагүй, ажил гүйцэтгээгүй байхад шилжүүлж тайланд авлагаар тусгаагүй байна

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа үйлчилгээний зардал зарцуулахдаа тухай бүр тушаал шийдвэр гаргадаггүй, анхан шатны бүрдэл дутуу гүйлгээ хийдэг, бараа материалын орлого авахдаа биетээр оршин байгаа байдлыг харгалзан үзэлгүй орлого авдаг, нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдэж байгаа материал, шатахууны орлогыг нярав бүрэн аваагүй, тооцоог бодоогүй шатахуун үнийг илүү шилжүүлж оны эцэст их хэмжээгээр нөөцөлж үлдэгдэлтэй гарсан, үр дүнгийн урамшуулалт цалинг давхардуулан шийдвэр гаргаж олгодог зэрэг зөрчил гарсан ба аудитын цаг хугацаанаас хамаарч нэг бүрчлэн үзэх боломжгүй байгаа тул цалинг давхардуулан шийдвэр гаргаж олгодог зэрэг зөрчил гарсан ба аудитын цаг хугацаанаас хамаарч нэг бүрчлэн үзэх боломжгүй байгаа тул Эрүүл мэндийн яамны дотоод аудит энэ асуудал дээр анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллээс 122 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	4	2	5
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	1	1
4	Сар бүр	3	36	29	7	
5	Тухай бүр	8	96	83	13	
6	Нийт	27	151	122	23	6

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5958.0 мянган төгрөгийн зөрчилд 5958.3 төлбөрийн акт тогтоосноос 5958.3 мянган төгрөгийг барагдуулсан, 44630.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан тухай албан тоотоор хариу ирүүлсэн.

Гэтэл тус газар нь урьд онд үр дүнгийн урамшууллыг улирал бүр авдаг атлаа давхардуулан жилийн ажлын гүйцэтгэлийн нэмэгдэл 5958,0 мянган төгрөг авч акт тогтоон зөвлөмж өгсөн байхад 2019.12.17-ны өдөр дээрх алдааг давтан шийдвэр гаргаж жилийн ажлын гүйцэтгэлд 9302,7 мянган төгрөг олгосон байна

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлын тооцоог тулган шалгахад нярвын тайлангаар 22615,3 мянган төгрөгийн орлого авч /үүнд урамшууллын 497,1 мянган төгрөгийн орлого орсон/, зарцуулан 3768,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд 26752,9 мянган төгрөгийн орлого авч, оны эцэст 4754,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч тайлан зөрүүтэй байна. Энэ нь нярав нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлсэн шатахууныг орлого авч тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүйгээс 4137,6 мянган төгрөгийн орлого, 3151,8 мянган төгрөгийн зарлага, үлдэгдэл 985,7 мянган төгрөгийн тайланг нотлох боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна

1.2. Эрсдэл:

Төсвийг зориулалт бусаар зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Шатахууны тайланг анхан шатны баримтыг үндэслэн орлого авч, холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр зарлага гарган, сар бүр харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, тухай бүр нь картыг цэнэглэж, гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулан НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны буцаж орж 30600.0 мянган төгрөгөөс 12-р сард тушаал шийдвэргүй "Өлзийтийн хиймор өөдөө" ХХК руу гэрээний төлбөр 700.0 мянган төгрөг, Залуу уран бүтээлчдийн холбоо руу "Жаргалын наран" уран сайхны киноны мөнгө 2500.0 мянган төгрөг шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах 6.4.1-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах журмыг хэрэгжүүлэх" тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Төсвийг зориулалт бусаар зарцуулах, төсөв үр ашиггүй зарцуулагдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогоос зардал гаргахдаа зардал гарсан тухай бүр тушаал шийдвэр гаргаж, зориулалтын дагуу зарцуулж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагын биет бус хөрөнгөнд 200,0 мянган төгрөгийн өртөг бүхий архивын программ, 264,0 мянган төгрөгийн өртөг бүхий пластик шинэчлэл гэсэн нэгтгэлийн программ одоогоор ашиглалтгүй хөрөнгө бүртгэлтэй байна.

3.2.2 Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Ашиглалтгүй байгаа программ хангамжуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого 30600.0 мянган төгрөгөөс 12-р сард Эрүүл мэндийн газрын даргын 2019.12.26-ны өдрийн А/133 дугаар тушаалаар илрүүлэг үзлэгт шаардлагатай оношлуур авахаар 22348.0 мянган төгрөг зарцуулах шийдвэр гаргасны дагуу 19348.0 мянган төгрөгийг Монос трейд ХХК-д шилжүүлсэн байна. Гэтэл дээрх шилжүүлсэн мөнгөний нэхэмжлэх нь 2020.01.14-ны өдрийн байдлаар өгсөн байгаагаас үзэхэд тайлант хугацаанд бодитой оршин байх тодорхойлогдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Энэ нь Бодитой оршин байх тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйл: анхан шатны баримт 14 дүгээр зүйл: Нягтлан бодох бүртгэл хөтлөх "13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 4.4: Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ тус тус зөрчсөн байна.

4.2 Эрсдэл:

хөрөнгө дутагдах

4.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материал болон үндсэн хөрөнгийг орлого авахдаа хөрөнгө ирээгүй байхад хөрөнгөнд орлого авч, үлдэгдлээр тайлагнадаг явдлыг таслан зогсоох. НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

5.1 Илрүүлэлт:

Төсөвт зардлаас зориулалт бусаар БҮТЭЗ-ийн зардлаас 2019.05.13-ны өдөр Их халбагант ХХК-аас 400.0 мянган төгрөгийн бэлгийн багц, БҮЗ-аас буудлын үнэнд 2019.07.25-нд Өлзийт палас ХХК-д 85.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, Шаргалжуут рашаан сувилал ХХК-д 2019.12.26-нд 2019 оны 4,5 сард амарсан амрагчдын 1310.0 мянган төгрөг тус тус шилжүүлж, тайланд авлагаар тусгаагүй байна. Мөн Эрүүл мэндийн газрын даргын 2019.12.25-ны өдрийн А/128 дугаар тушаалаар Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 44.1.2, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/346 дугаар тушаал, байгууллагын хамтын гэрээний 7.15 дах заалтыг үндэслэн байгууллагын ажилтан албан хаагчид, тэдний 0-18 насны хүүхдүүдэд амин дэм, утаанаас хамгаалах маскаар хангахад зориулан төсвөөс 3994.5 мянган төгрөгийг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас санхүүжүүлж төсвийг зориулалт бусаар нийт 5789,5 мянган төгрөгийг зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8"төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, тохиолдсон байх, эрх үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

5.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

5.3 Өгсөн зөвлөмж:

Бараа үйлчилгээний зардал болон бусад зардлаас зориулалт бусаар, шийдвэргүй хөрөнгө гарган зарцуулдаг явдлыг таслан зогсоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу тушаал шийдвэр гарган анхан шатны баримтыг үндэслэн зарцуулж байх

5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>73,643,312.85</u>	<u>105,467,016.10</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,000,000.00	5,000,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,000,000.00	00.00
31110	Төгрөг	2,000,000.00	00.00
33	АВЛАГА	30,600,000.00	7,673,947.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	30,600,000.00	7,551,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,043,312.85	92,793,069.10
351	Түүхий эд материал	30,116,299.10	76,023,937.35
35110	Тусгай зориулалттай материал	24,354,704.10	21,373,860.10
35130	Эм боох материал	5,761,595.00	54,650,077.25
354	Хангамжийн материал	10,927,013.75	16,769,131.75
35410	Бичиг хэргийн материал	2,417,563.00	1,461,550.00
35420	Аж ахуйн материал	7,211,020.00	7,971,200.00
35450	Барилгын засварын материал	546,300.00	627,300.00
35470	Бусад хангамжийн материал	752,130.75	679,630.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,221,629,571.72</u>	<u>1,224,062,247.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,221,629,571.72	1,224,062,247.11
392	Биет хөрөнгө	1,059,054,571.72	1,059,229,434.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,245,798.51	817,245,798.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-355,099.08	-29,275,085.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	156,821,297.08	240,821,297.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	-85,051,297.00	-112,137,963.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,975,345.00	168,083,245.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,720,700.38	-127,941,499.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,923,080.44	205,453,080.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,454,852.85	-103,690,438.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,042,350.00	1,042,350.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,350.00	-371,350.00
393	Биет бус хөрөнгө	162,575,000.00	164,832,812.49
39301	Програм хангамж	1,364,000.00	1,639,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,364,000.00	-1,381,187.51
39303	Бусад биет бус хөрөнгө	162,775,000.00	164,775,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>1,295,272,884.57</u>	<u>1,329,529,263.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>30,802,983.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,802,983.00	00.00
413	Өглөг	30,802,983.00	00.00
4136	Бусад өглөг	30,802,983.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	30,600,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	202,983.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,264,469,901.57</u>	<u>1,329,529,263.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,264,469,901.57	1,329,529,263.21

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	755,146,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	755,146,079.04	755,146,079.04
512	Хуримтлагдсан үр дүн	-246,864,986.42	-181,805,624.78
51210	Өмнөх үеийн үр дүн	-343,360,586.13	-216,264,986.42
51220	Тайлант үеийн үр дүн	96,495,599.71	34,459,361.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	756,188,808.95	756,188,808.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,295,272,884.57</u>	<u>1,329,529,263.21</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,121,750,989.34	1,889,374,394.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,928,300.08	337,245,594.25
120	Нийтлэг татварын бус орлого	6,878,300.00	337,245,594.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	335,240.00	337,245,594.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	335,240.00	337,245,594.25
120009	Бусад орлого	6,543,060.00	00.00
122	Тусламжийн орлого	82,050,000.08	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	82,050,000.08	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,032,822,689.26	1,552,128,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,822,077,200.00	1,442,703,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,822,077,200.00	1,442,703,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,418,284.26	109,425,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	104,433,244.26	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,383,000.00	3,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,788,040.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,814,000.00	106,155,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,327,205.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,327,205.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,017,476,194.85	1,854,915,032.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,017,476,194.85	1,854,915,032.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	903,637,513.85	1,114,817,437.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,349,200.70	444,573,913.00
210101	Үндсэн цалин	434,349,200.70	444,573,913.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,615,117.67	55,566,981.38
210201	Тэтгэврийн даатгал	35,049,328.47	38,548,582.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,343,765.79	4,500,629.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,475,012.68	3,559,545.00
210204	Ажилгүйдлийн даатгал	795,182.07	814,385.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,951,828.66	8,143,840.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,978,200.00	82,788,558.00
210301	Гэрэл, цахилгаан	4,889,126.00	5,406,694.00
210302	Түлш, халаалт	57,593,250.00	61,869,500.00
210303	Цэвэр, бохир ус	15,495,824.00	15,512,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,612,402.00	57,217,859.79
210401	Бичиг хэрэг	3,781,200.00	10,066,387.00
210402	Тээвэр, шатахуун	19,381,310.00	21,561,748.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,398,253.00	1,740,130.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	131,000.00	498,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,920,639.00	14,854,300.00
2105	Нормативт зардал	5,497,900.00	221,578,917.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,497,900.00	221,578,917.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,458,450.00	13,551,171.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	84,700.00	690,500.00
210604	Урсгал засвар	17,373,750.00	11,390,671.00
2107	Томилолт, зочны зардал	11,026,500.00	14,908,000.00
210702	Дотоод албан томилолт	11,026,500.00	14,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	203,112,895.26	115,434,002.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,934,307.26	107,475,076.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	381,100.00	384,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	645,360.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	477,766.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,521,000.00	5,691,500.29
210807	Газрын төлбөр	51,888.00	650,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,986,848.22	109,198,034.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,496,300.00	12,842,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	995,000.00	875,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,495,548.22	95,480,224.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,113,838,681.00	740,097,595.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,070,061,165.00	690,718,987.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,327,205.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	328,134,200.00	393,955,087.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	729,749,760.00	291,905,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00	4,858,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,777,516.00	49,378,608.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,777,516.00	49,378,608.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	104,274,794.49	34,459,361.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,576,211.78	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,552,434.98	00.00

225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,023,776.80	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,576,211.78	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>96,698,582.71</u>	<u>34,459,361.64</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,047,464,210.26</u>	<u>1,588,739,022.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,047,464,210.26</u>	<u>1,587,728,800.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,822,077,200.00	1,442,703,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,822,077,200.00	1,442,703,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,059,805.26	145,025,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	116,228,765.26	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,383,000.00	3,270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,634,040.00	30,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,814,000.00	111,155,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,327,205.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,327,205.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,953,283,210.26</u>	<u>1,571,826,122.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,953,283,210.26</u>	<u>1,571,826,122.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>843,074,371.26</u>	<u>822,075,443.46</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	435,749,199.00	447,562,325.00
210101	Үндсэн цалин	435,749,199.00	304,565,725.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,571,629.00	56,117,138.38
210201	Тэтгэврийн даатгал	51,571,629.00	39,281,023.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,978,200.00	82,351,858.00
210301	Гэрэл, цахилгаан	4,889,126.00	5,406,694.00
210302	Түлш, халаалт	57,593,250.00	61,432,800.00
210303	Цэвэр, бохир ус	15,495,824.00	15,512,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,911,550.00	33,434,220.79
210401	Бичиг хэрэг	4,477,247.00	4,849,640.00
210402	Тээвэр, шатахуун	19,032,700.00	22,530,940.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,253.00	1,648,240.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	131,000.00	498,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,854,350.00	3,906,800.00
2105	Нормативт зардал	4,886,200.00	4,502,464.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,558,200.00	4,502,464.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	328,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,366,400.00	20,718,951.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,744,800.00	2,850,780.00
210602	Тавилга	429,600.00	1,889,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	792,000.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	21,400,000.00	13,379,171.00
2107	Томилолт, зочны зардал	11,026,500.00	14,908,000.00
210702	Дотоод албан томилолт	11,026,500.00	14,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,093,393.26	142,377,626.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,459,805.26	132,474,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	381,100.00	384,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	645,360.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	477,766.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,976,000.00	7,636,000.29
210807	Газрын төлбөр	51,888.00	650,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,491,300.00	20,102,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,496,300.00	18,759,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	995,000.00	1,343,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,208,839.00	749,750,678.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,066,431,323.00	692,820,470.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,327,205.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	327,639,700.00	394,158,070.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	726,614,418.00	291,905,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00	6,757,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,777,516.00	49,378,608.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,777,516.00	49,378,608.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>94,181,000.00</u>	<u>16,912,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	92,181,000.00	13,912,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,181,000.00	13,912,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	92,181,000.00	13,912,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	92,181,000.00	13,912,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-92,181,000.00</u>	<u>-13,912,900.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,000,000.00	3,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,000,000.00	5,000,000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	592,571,079.04	500,736,803.00	-343,360,586.13	749,947,295.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	592,571,079.04	500,736,803.00	-343,360,586.13	749,947,295.91
C07	Тайлант үеийн үр дүн	162,575,000.00	00.00	96,698,582.71	259,273,582.71
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	30,600,000.00	30,600,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-216,264,986.42	1,295,069,901.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,459,361.64	34,459,361.64
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-181,805,624.78	1,329,529,263.21

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,442,703,000.00	1,393,324,391.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,442,703,000.00	1,393,324,391.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	749,485,300.00	700,503,921.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,944,400.00	447,296,103.00
210101	Үндсэн цалин	330,947,800.00	304,299,503.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,130,000.00	50,130,000.00
210104	Урамшуулал	33,059,000.00	33,059,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,243,100.00	56,117,138.38
210201	Тэтгэврийн даатгал	40,285,300.00	39,281,023.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,428,100.00	82,351,858.00
210301	Гэрэл, цахилгаан	6,568,700.00	5,406,694.00
210302	Түлш, халаалт	61,432,800.00	61,432,800.00
210303	Цэвэр, бохир ус	20,426,600.00	15,512,364.00

2104	Хангамж, бараа материалын зардал	35,734,300.00	33,434,220.79
210401	Бичиг хэрэг	5,940,200.00	4,849,640.00
210402	Тээвэр, шатахуун	22,621,500.00	22,530,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,783,300.00	1,648,240.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,666,000.00	498,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,723,300.00	3,906,800.00
2105	Нормативт зардал	4,892,600.00	4,502,464.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,558,200.00	4,502,464.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	334,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,533,600.00	31,439,851.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	10,460,680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	20,325,000.00	13,379,171.00
2107	Томилолт, зочны зардал	15,870,000.00	14,908,000.00
210702	Дотоод албан томилолт	15,870,000.00	14,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,192,100.00	10,671,426.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	384,000.00	384,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	645,360.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	477,766.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	8,404,000.29
210807	Газрын төлбөр	650,500.00	650,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20647100.00	19782860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,555,800.00	18,439,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,091,300.00	1,343,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	693217700.00	692820470.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	693,217,700.00	692,820,470.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	394,284,800.00	394,158,070.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	291,905,100.00	291,905,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,442,703,000.00	1,393,324,391.46
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,442,703,000.00	1,393,324,391.46
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,442,703,000.00	1,393,324,391.46
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.00	42.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	08.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	46.00	42.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	29.00	25.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	02.00	02.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	182459805.26	134,474,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	182459805.26	134,474,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	182459805.26	134,474,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182459805.26	134,474,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184459805.26	134,474,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		137474200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116228765.26	137,474,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8783000.00	1,429,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55634040.00	30,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3814000.00	105,445,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: *Н.Бунчинсүрэн* Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.27

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.Цээням* А.ЦЭЭНЯМ 2020.02.27

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ 2020.02.27